



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

“Рескап секьюритис” ХХК-ийн тусгай  
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30.1.1, 63.1.5 дахь заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 11.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Рескап секьюритис” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Рескап секьюритис” ХХК-ийн нийт 441 харилцагчдыг “Эм Ай Би Жи” ХХК болон “Рескап” ХХК-ийн 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Хамтран ажиллах гэрээ”, тус компанийн харилцагчдын зөвшөөрлийг үндэслэн “Эм Ай Би Жи” ХХК-д бүрэн шилжүүлсэн болохыг тэмдэглэсүгэй.

3. “Рескап секьюритис” ХХК-ийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч ажиллахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/-т үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт, харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000156